Оюутнуудын тамхи таталтын түвшин, эрүүл мэндийн эрсдэлт зан үйлийн судалгаа

Б.Намуунцэцэг[1], А.Баярцэцэг[1], Ц.Дваасүрэн[1], Б.Азжаргал[1]

[1]АШУҮИС, Сувилахуйн сургууль, Сувилахуйн 4р дамжаа, 401 хэсэг
[1]АШУҮИС, Сувилахуйн сургууль, ЭБЭХСТ
Цахим шуудан: Azjargal.b@mnums.edu.mn, Утас: 99102855

Түлхүүр үг:
Тамхины ойлголт
Тамхины хамаарал
Эрүүл мэндийн эрсдэлт зан үйл

Товч утга:
Үндэслэл: Shekari F (2020) нарын АНУ-д хийсэн судалгаанд эрсдэлт зан үйлийн улмаас эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх магдлалтай байна хэмээн үзжээ. Сүүлийн жилүүдэд электрон тамхины хэрэглээ Монгол улсад нэмэгдэх хандлагатай байгааг бидний эргэн тойронд хэн нэгэн хэрэглэж байгаагаар дүгнэж болох юм. Эрсдэлт зан үйл гэдэг нь өөрт болон бусдын эрүүл мэндэд хохирол учруулах эрсдэлтэй, өвчлөл, нас баралт үүсгэдэг зан үйл юм. Иймээс оюутнуудын дунд тамхины хамааралт түвшин болон эрсдэлт зан үйлийн судалгаа хийгдээгүй байгаа нь бидний судалгааны үндэслэл болж байна. **Зорилго:** Сувилахуйн сургуулийн оюутнуудын дунд тамхи таталт, эрсдэлт зан үйлийн судлах. **Арга, аргачлал:** Судалгааг агшингийн загвараар, тоон судалгааны аргаар хийж гүйцэтгэв. I- IV дамжааны оюутнуудыг сайн дурын үндсэн дээр хамрууллаа. **Үр дүн:** Нийт судалгаанд хамрагдагсдын 87.8% нь эмэгтэй, 12.2% нь эрэгтэй оюутнууд байна. Судалгаанд хамрагдагсдын 50.2% нь тамхи татдаг байна. **Дүгнэлт:** Шинжлэх ухааны ойлголт сул, тамхины хамаарал нь дундаас дээш хамааралтай байсан ба эрсдэлт зан үйлд тамхины хэрэглээ, архины хэрэглээ,марихуаны хэрэглээ, дээрэлхэлт, хүчирхийлэл, бэлгийн харилцаа, гунигтай мэдрэмж буюу амиа хорлох бодол, зурагт дэлгэцийн хамаарал, кола ундааны хэрэглээ зэрэг нь хамаарч байна.

Үндэслэл: Л.Эрдэнэбаатар нарын (2008) судалгаанд тамхи гэдэг нь татаж хэрэглэх зориулалттай тайвшруулах бодис агуулсан никотин хэмээх нэмэлт донтуулагч бодис агуулсан сэтгэцэд нөлөөлдөг бодис юм.[1] Shekari F (2020) нарын АНУ-д хийсэн судалгаанд эрсдэлт зан үйлийн улмаас эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай байна хэмээн үзжээ.[2] Tahir Ansari TA (2016) нарын Англи болон Саудын Арабд хийгдсэн эрсдэлт зан үйлийн судалгаанаас үзэхэд өсвөр насныхны дунд хөдөлгөөний хомсдол болон хурд өндөртэй техник жолоодох зэрэг нь зо нарын нхилж байна.[3]

Pietinalho, A (2009) нарын Финланд улсад хийгдсэн судалгаагаар бага насны хүүхдүүд болон жирэмсэн эмэгтэйчүүд тамхины утаанд ихээр өртөж хүүхэд астма өвчтэй болох магадлал өндөртэй хэмээн тодорхойлсон байна.[4] Lee, V.W.Y (2021) Хонг-Конг улсын Вивиян нарын судлаачид Ази Номхон Далайн орнуудын тамхины шалтгаант дарамтыг тодорхойлохдоо эдийн засгийн буюу санхүүгийн дарамт хэмээн үзэж хэрэглээгээ багасгах тухай цохон тэмдэглэжээ.[5] Reitsma, M. B (1990-2019) нарын судалгаанд 100 гаруй сая хүн тамхи татдаг гэсэн тооцоо гарсан бөгөөд тоо баримтаас харахад дийлэнх хувь нь өсвөр насандаа тамхи татаж эхэлсэн байна.[6] American College Health Association (2016) нар судалгаандаа их дээд сургуулийн оюутнуудын ихэнх хувь нь тамхи татдаг ба амьдралынхаа туршид тамхи татаж болзошгүй хэмээн тодорхойлсон бөгөөд нэгэнт тогтсон зуршлаа солих нь бие организмд тун таагүй нөлөө үзүүлдэг байна хэмээн тодорхойлжээ.[7] Rayens M (2017) нар их сургууль, коллежийн оюутнууд тамхи татах магадлал нь өндөр байгаа бөгөөд тамхины талаар судлах шаардлагатай хэмээн үзсэн байна.[8]

Shariful Islam M (2022) нарын Ази тивд хийсэн судалгаагаар дунд болон бага орлоготой зарим орнууд тамхинаас үүдэлтэй нас баралт, хөгжлийн бэрхшээл зэргийг хэлэлцэж байгаа бөгөөд тухайн улс орны онцлог байдалд нь тохирсон хөтөлбөр хэрэгжүүлнэ гэж үзсэн байна.[9] Patil S (2022) нарын судалгаанд тамхинаас үүдэлтэй нас баралт, хөгжлийн бэрхшээл нь өнөө үеийн эрүүл мэндийн хамгийн том асуудал болж байна хэмээн тодорхойлсон байна. Тамхи татах нь эмэгтэй хүний бие организмд эрчүүдийнхээс илүү

их хор хөнөөлтэй байдаг.[10] Иймээс оюутнуудын дунд тамхины хамааралт түвшин болон эрсдэлт зан үйлийн судалгаа хийгдээгүй байгаа нь бидний судалгааны үндэслэл болж байна.

Зорилго: АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн оюутнуудын дунд тамхи таталт, эрсдэлт зан үйлийн судлах

Зорилт:

1. Сувилахуйн сургуулийн оюутнуудын дунд тамхины талаарх ойлголтыг судлах
2. Тамхи татаж буй оюутнуудын тамхины хамаарлын зэргийг тодорхойлох
3. Эрсдэлт зан үйлийн хамаарлыг тодорхойлох

Арга, аргачлал: Судалгааг явуулахдаа аналитик судалгааны агшингийн загварыг ашиглан АШУҮИС Сувилахуйн сургуульд суралцаж буй 360 оюутныг санамсаргүй түүврийн аргаар сонгон асуумжийн хуудсыг ашиглан тамхины талаарх үнэн ба буруу ташаа ойлголтыг тодорхойлох 1 бүлэгт 8 асуумж, тамхи татаж буй оюутнуудад тамхины хамаарлын зэргийг тогтоох Фажерстремийн стандарт сорилын 1 бүлэгт 6 асуумж, эрүүл мэндийн эрсдэлт зан үйлийг судлах 9 бүлэгт 98 асуумжаар мэдээллийг цуглуулав. Асуумжийг тохирсон хариултыг бөглүүлэн судалгааг авав. 1 асуултанд хариулаагүй асуумжийг түүврээс хасч боловсруулалтыг хийж гүйцэтгэв. Нийт оюутны тоог (N=1441) суурь үзүүлэлт болгон авч 95 хувийн магадлал (1.96), алдааны хязгаар (0.05), түүврийн бус алдааг 5 хувиар тооцож 360 оюутныг судалгаанд хамруулав.

Статистик боловсруулалт: Судалгааны үр дүнгийн хүснэгт, дүрслэлийг Microsoft office 2016 иж бүрдэл, статистик боловсруулалтыг SPSS-25.0 програмаар мэдээ мэдээллийн өгөгдлийг кодлон шивж, алдааг шалган, тоон мэдээллийг боловсруулан, ном зүйг endnote програмаар хийж гүйцэтгэв. Үл хамааралт хувьсагчдыг шатлан сонгох аргаар олон хүчин зүйлийн регрессийг тооцсон ба P утга 0.05-аас бага байх тохиолдолд ялгааг статистикийн үнэн магадлалтай гэж үзсэн. Асуумжийн дотоод зохицол, найдвартай байдлыг Кронбах альфа коэффицентээр үнэлэхэд 0.76 байв.

Үр дүн: Түүврийн хэмжээг төлөвлөсний дагуу судалгаанд хамруулсан ба эмэгтэйчүүд 87.8% зонхилон хамрагдсан нь мэргэжил, хүйсийн байдал статистик ач холбогдол бүхий ялгаатай байна. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдагсдын ерөнхий мэдээлэл

Үзүүлэлтүүд	Мэргэжлийн байдлаар							
	СБ	ЭБ	РТ	ОТ	СДБ	УАУС	Бүгд	P утга
Эрэгтэй	2.7% (10)	0.01% (4)	3.3% (12)	1.9% (7)	2.7% (10)	0.27% (1)	12.2% (44)	
Эмэгтэй	26.1% (94)	21.1% (76)	11.6% (42)	7.7% (28)	16.4 (59)	4.7% (17)	87.8% (316)	0.027
Бүгд	**28.8% (104)**	**21.11% (80)**	**15% (54)**	**9.7% (35)**	**19.1% (69)**	**5% (18)**	**100% (360)**	

Судалгаанд сургуульд суралцаж буй нийт дамжааны оюутнуудыг хамруулснаас 1, 2-р дамжааны оюутнуудын суралцаж буй тоо (63.2%) бусад дамжаанаасаа олон байгааг харуулсан. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Судалгаанд хамрагдагсдын суралцаж буй дамжаа (Хүйсээр)

Үзүүлэлтүүд	Дамжаагаар				Бүгд	P утга
	I % (n)	II % (n)	III % (n)	IV % (n)		
Эрэгтэй	2.7% (10)	4.7% (17)	2.7% (10)	1.9% (7)	12.2% (44)	
Эмэгтэй	29.1% (105)	26.6% (96)	17.5% (63)	14.4% (52)	87.8% (316)	0.507
Бүгд	**31.9% (115**	**31.3% (113)**	**20.2% (73)**	**16.4% (59)**	**100% (360)**	

Тамхи татдаг эсэхийг тодорхойлоход нийт судалгаанд хамрагдагсдын 50.2% нь тамхи татаж байгаа нь асуумжаар тогтоогдсоноос РТ, ЭБ мэргэжлийн ангийн оюутнууд бусад мэргэжлээс хамгийн өндөр хувьтай байгаа нь ажиглагдаж байгаа нь харагдаж байна. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Судалгаанд хамрагдагсдын Тамхи татдаг эсэхийг тодорхойлсон дүн (Мэргэжлээр)

Мэргэжил	Тамхи татдаг эсэх		Бүгд	P утга
	Тийм	Үгүй		
СБ	6.6% (24)	22.2% (80)	28.9% (104)	
ЭБ	12.5% (45)	9.7% (35)	22.2% (80)	
РТ	12.8% (46)	2.2% (8)	15% (54)	
ОТ	6.6% (24)	3.05% (11)	9.7% (35)	0.000
СДБ	8.9% (32)	10.3% (37)	19.1% (69)	
УАУС	2.7% (10)	2.2% (8)	5% (18)	
Бүгд	**50.2% (181)**	**49.7% (179)**	**100% (360)**	

Тамхины хэлбэрийн төрлөөр хэрэглээг судалж үзэхэд янжуурыг 36.4%, электрон тамхийг 56.4% хэрэглэж байгаагаас харахад бусад тамхины хэрэглээнээс өндөр байна. Хүйсийн хувьд эрэгтэй, эмэгтэй ялгаагүй хэрэглэж байгаа нь тогтоогдож байна. (Хүснэгт 4)

Хүснэгт 4. Судалгаанд хамрагдагсдын хэрэглэж буй татаж буй тамхины хэлбэрүүдийг судалсан дүн (Хүйсээр)

Хүйс	Татдаг тамхины хэлбэрүүд						
	Янжуур	Vape	Зөөлөн янжуур	Ороодог янжуур	Гаанс	Шингэн	Huuka Усан
Эрэгтэй	57 (15.8%)	94 (26.1%)	7 (1.9%)	1 (0.2%)	2 (0.4%)	1 (0.2%)	1 (0.2%)
Эмэгтэй	74 (20.6%)	109 (30.3%)	9 (2.5%)	1 (0.2%)	2 (0.4%)	1 (0.2%)	2 (0.4%)

Судалгаанд хамрагдагсдын 43.6% нь тамхи татаж байгаа нь тамхи татдаг нийт хамрагдагсдын тоотой ойролцоо байгаа нь харагдаж байгаа нь тодорхой түвшинд гэр бүлийн зан үйлийн нөлөө байгааг харж байна. (Хүснэгт 5)

Хүснэгт 5. Судалгаанд хамрагдагсдын гэр бүлийнхэн тамхи татдаг эсэхийг судалсан дүн (Мэргэжлээр)

Мэргэжлүүд	Гэр бүлд тамхи татдаг эсэх		Бүгд	P утга
	Тийм	Үгүй		
СБ	9.7% (35)	19.2% (69)	28.9% (104)	
ЭБ	9.4% (34)	12.8% (46)	22.2% (80)	
РТ	9.4% (34)	5.5% (20)	15% (54)	
ОТ	5.5% (20)	4.2% (15)	9.7% (35)	0.022
СДБ	6.9% (25)	11.9% (43)	19.2% (69)	
УАУС	2.5% (9)	2.5% (9)	5% (18)	
Бүгд	**43.6% (157)**	**56.1% (202)**	**100% (360)**	

Тамхины үнэн ба буруу ташаа ойлголтуудыг судалж үзэхэд асуулт 4, 7, 8-д ойлголтын хувьд дутмаг байгаа нь харагдаж байна. 4-р асуултын хувьд нарийн шүүлтүүртэй тамхи бусад тамхины адил хор нөлөөтэй байдаг болох тухай, 7-р асуултанд тамхиа хаясан тохиолдолд эрүүл мэндэд учрах эрсдэл 50% буурах тухай, 8-р асуултын хувьд тамхи татдаг ч бусад эрүүл зан үйл өөрийг нь аварна гэж бодож буй байдал нь буруу ойлголт болох тухай зэргийн талаар ойлголт сул байгаа нь харагдаж байна. Эндээс харахад сэтгэл зүйн төлөвшлийн насанд тамхины талаарх ойлголт сул байгаагаас сэтгэцийн эрүүл мэндэд гэмтэл учруулах эрсдэлтэй байгаа нь тодорхойлогдлоо. (Хүснэгт 6)

Хүснэгт 6. Судалгаанд хамрагсдын тамхины талаарх ойлголтыг судалсан үр дүн (Тамхины талаарх бодол санаа)

Асуулт	Үнэн		Бүгд	Зөв хариулт	P утга
	Тийм	Үгүй			
Үнэн ба худал 1	94.1% (339)	5,8% (21)	100% (360)	Тийм	0.007
Үнэн ба худал 2	86.9% (313)	13% (47)	100% (360)	Тийм	0.062
Үнэн ба худал 3	89.4% (322)	10.5% (38)	100% (360)	Тийм	0.003
Үнэн ба худал 4	73.3% (264)	26.7% (96)	100% (360)	Үгүй	0.025
Үнэн ба худал 5	85.3% (307)	14.7% (53)	100% (360)	Тийм	0
Үнэн ба худал 6	72.5% (261)	27.5% (99)	100% (360)	Тийм	0.03
Үнэн ба худал 7	55.3% (199)	44.7% (161)	100% (360)	Үгүй	0.11
Үнэн ба худал 8	62.8% (226)	37.2% (134)	100% (360)	Үгүй	0.008

Тамхи татдаг оюутнуудаас бие махбодийн никотины хамаарлын сорилыг авч үзэхэд хамаарлын хувьд дундаас дээгүүр зэрэг тодорхойлогдсон нь зан үйлийн эрсдлийг бий болгож байна. (Хүснэгт 7)

Хүснэгт 7. Судалгаанд хамрагдагсдын тамхины хамаарлын зэргийг тодорхойлсон үр дүн

Хамаарлын зэрэг	Оноо	Тоо	Хувь
Маш бага хамааралтай	(0-2)	6	3.3%
Бага хамааралтай	(3-4)	63	34.8%
Дунд зэргийн хамааралтай	“5”	45	24.8%
Өндөр хамааралтай	(6-7)	66	36.5%
Маш өндөр хамааралтай	(8>)	1	0.6%
Бүгд		**181**	**100%**

Эрсдэлт зан үйлд аюулгүй байдал, хүчирхийлэл, дээрэлхэлт, гунигтай мэдрэмж, тамхи мансууруулах бодис хэрэглэх, архи согтууруулах ундаа хэрэглэх, бэлгийн чиг хандлага өөрчлөгдөх, биеийн жин зэрэг хамааралтай байна. (Хүснэгт 8)

Хүснэгт 8. Судалгаанд хамрагдагсдын эрсдэлт зан үйлийн логистик регрессийн шинжилгээний үр дүн

Зан үйл	B	SE	Beta	t	P утга
Аюулгүй байдал	1.827	0.335	0.167	5.451	0.000
Хүчирхийлэл	2.725	0.337	0.247	8.084	0.000
Дээрэлхэлт	3.259	0.891	0.115	3.656	0.000
Гунигтай мэдрэмж	0.470	0.452	0.031	1.038	0.300
Тамхи	0.823	0.092	0.285	8.978	0.000
Архи	1.154	0.131	0.286	8.826	0.000
Мариухан	2.208	0.574	0.115	3.844	0.000
Бэлгийн хандлага	1.093	0.082	0.415	13.326	0.000
Биеийн жин	2.088	0.385	0.160	5.425	0.000
R=.839					
R2=.704					
Adjusted R=.697					
F=92.364	P=.000				

Эрсдэлт зан үйлд нөлөөлж буй хүчин зүйлийг харахад дамжаа нөлөөлөх ба энэ нь дамжаа ахих тусам боловсрол дээшлэн эрсдэлт зан үйлийг танин мэдэх нь хамааралтай байгааг харуулж байна. (Хүснэгт 9)

Хүснэгт 9. Судалгаанд хамрагдагсдын нөлөөлөх хүчин зүйлийн логистик регрессийн шинжилгээний үр дүн

Нөлөөлөх хүчин зүйл	B	SE	Beta	t	P утга
Мэргэжил	0.679	0.534	0.081	1.270	0.205
Хүйс	-3.665	2.104	-0.093	-1.742	0.082
Дамжаа	1.433	0.696	0.111	2.059	0.040
Боловсролын зэрэг	1.689	2.093	0.050	0.807	0.420
R=.177					
R2=.030					
Adjusted R=.020					
F=2.822	P=.000				

Хэлцэмж: Тамхи татаж буй байдлыг хэлбэрээр нь судалж үзэхэд усан тамхи татаж буй оюутнуудын эзлэх хувь 0.8 % байсан үр дүнг Палестины их сургуулийн оюутнуудын дундах усан тамхи татдаг оюутнуудын эзлэх хувьтай харьцуулж үзэхэд 123.5 дахин бага, Жорданы их сургуулийн оюутнуудын дундах усан тамхи татдаг оюутнуудын эзлэх хувьтай харьцуулж үзэхэд 122 дахин бага, Туркийн их сургуулийн оюутнуудын дундах усан тамхи татдаг оюутнуудын эзлэх хувьтай харьцуулж үзэхэд 91.8 дахин бага байна.[35] БНСУ-ын Гачон их сургуулийн оюутнуудын дундах электрон тамхи хэрэглэдэг оюутнуудын эзлэх хувьтай харьцуулж үзэхэд эрэгтэй оюутнуудаас 12.1 дахин бага, эмэгтэй оюутнуудаас 8.8 дахин бага байна.[38]

Самоа улсад хийгдсэн оюутнуудын дундах ар гэрт тамхи татаж буй байдал буюу аав нь тамхи татдаг гэсэн хариулт нь бидний судалгааны үр дүнтэй ойролцоо байна. Харин ээж нь тамхи татдаг гэсэн хариултын үр дүн 13.6 дахин бага буюу ялгаатай байна.[38]

АНУ-ын ахлах сургуулийн сурагчдын дунд хийсэн судалгааны үр дүнг бидний судалгааны үр дүнтэй харьцуулахад янжуур тамхи татаж буй байдал 3.3 дахин бага, электрон тамхи татаж буй байдал 1.3 дахин бага, ороодог тамхи татаж буй байдал 17 дахин их байна.[35]

Бидний судалгаанд нийт 360 оюутан хамрагдснаас тамхи татдаг хэмээн хариулсан 185 оюутнуудад тамхины хамаарлын зэргийг буюу Никотины хамаарлын түвшинг тодорхойлов. Энэ нь тамхи татаж буй оюутнуудад цаашид тамхинаас гаргах сэтгэлзүйн зөвлөгөө, ганцаарчилсан зөвлөгөө, харилцан нөлөөлөх бүлгийн сэтгэл заслыг хийхэд ач холбогдолтой юм. Тамхины хамаарлын зэргийн судалгаанд нийт 185 оюутан оролцсоны 5.4% нь маш бага хамааралтай, 34% нь бага хамааралтай, 24.3% нь дунд зэргийн хамааралтай, 35.6% нь өндөр хамааралтай, 0.54% нь маш өндөр хамааралтай байна. Эдгээр үр дүнг О.Тэмүүлэн нарын судлаачдын судалгааны үр дүнтэй харьцуулж үзэхэд маш бага хамааралтай 2.6 дахин бага, бага хамааралтай 1.24 дахин их, дунд зэргийн хамааралтай 1.34 дахин их, өндөр хамааралтай 1.08 дахин их, маш өндөр хамааралтай 16 дахин бага бүхий үзүүлэлттэй байна. Эндээс харахад оюутнуудын тамхины хэрэглээ анхаарал татахуйц түвшинд хүрч сэтгэл зүйн төлөвшил улмаар тархины үйл ажиллагаанд ой тогтоолтын чадвар оюуны үйлдэл буурах эрсдэл бий болж болзошгүй юм. Цааш даамжран амархан ядрах, цочромтгой болох, толгой өвдөх, нойргүйдэх, уур уцаартай болох зэргээр суралцах үйл ажиллагаа буурах эрсдэлтэй гэж үзэж байна.[26]

Эрүүл мэндийн эрсдэлт зан үйлийг харьцуулан судлахын тулд Behaviours AND tobacco AND health risk гэсэн түлхүүр үгээр хайлт хийхэд Pubmed-ийн илэрц 597 өгүүлэл илэрснээс доорх өгүүллийн үр дүнг харьцуулан судаллаа.

Эрүүл мэндийн зан үйлийн судалгааны үр дүнг харахад оюутнуудын дундах эрүүл зан үйлийн тухай ойлголтод эрүүл хооллолт, дасгал, хөдөлгөөн, ус уух, жимс, хүнсний ногоо зэргийг хамааруулж авч үзсэн байна. Эрүүл мэндийн эрсдэлт зан үйлд согтууруулах ундааны хэрэглээ (r=.38) P=.000, тамхины хэрэглээ (r=.30) P=.000, зурагтны хэрэглээ (r=.38) P=.000 зэрэг нь дунд зэрэг хамааралтай байна. Харин коланы хэрэглээ, компьютерын хэрэглээ, хүчирхийлэх зан үйл, дээрэлхэх, гунигтай мэдрэмж төрөх, бэлгийн харилцаа, марихуаны хэрэглээ зэрэг нь (r=.10-.27) P=.000 буюу сул хамааралтай байна. Олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээгээр мэргэжил, дамжаа, хүйсийг авч үзэхэд дамжаа хамааралтай гарсан байна. (P=.04) Эдгээр үр дүнг АНУ-ын судлаач Кателин нарын судалгааны үр дүнтэй харьцуулж үзэхэд бэлгийн эрсдэлтэй харилцаа, тамхины хэрэглээ,марихуаны хэрэглээ зэргийг эрсдэлтэй зан үйл хэмээн тодорхойлсон үр дүн нь ойролцоо байна. Эрүүл мэндийн эрсдэлт зан үйлийн улмаас уушгины бронхийн багтраа, нүүр амны хөндийн эрүүл мэндийн асуудлууд, төвлөрөх, шийдвэр гаргахад хүндрэлтэй болох, донтох эмгэгт өртөх, зүрх судасны өвчлөл зэрэг халдварт бус өвчний шалтгаан болдог.[39]

Оюутнууд өөрийн эрүүл мэндийн асуудал болон эрсдэлт зан үйлийн талаарх ойлголт нийт судлагдсан судалгаануудаас харахад сул байгаа нь анхаарал татаж байна.

Дүгнэлт:

1. Оюутнуудын дундах тамхины талаарх шинжлэх ухааны үндэслэл бүхий тайлбар ойлголт сул байна.
2. Судалгаанд хамрагдагсдын 5.4% нь маш бага хамааралтай, 34% нь бага хамааралтай, 24.3% нь дунд зэргийн хамааралтай, 35.6% нь өндөр хамааралтай 0.54% нь маш өндөр хамааралтай байна.
3. Эрүүл мэндийн эрсдэлт зан үйлд тамхины хэрэглээ, архины хэрэглээ, марихуаны хэрэглээ, дээрэлхэлт, хүчирхийлэл, бэлгийн харилцаа, гунигтай мэдрэмж буюу амиа хорлох бодол, зурагт дэлгэцийн хамаарал, кола ундааны хэрэглээ зэрэг нь хамаарч байна.

Ном зүй:

1. *Эрдэнэбаатар.Л, Донтох эмгэг судлал, УБ.2008.Соёмбо принтинг, 153х*
2. *Shekari F, Habibi P, Nadrian H, Mohammadpoorasl A. Health-risk behaviors among Iranian university students, 2019: a web-based survey. Arch Public Health. 2020;78(1):131. doi:10.1186/s13690-020-00514-y*
3. *Tahir Ansari TA, Mansour Alzahrani, Fahad Alfhaid1, WSDSA, Fahad S. Alshanbah3, Naif M. Almutairi3. Risky health behaviors among students in Majmaah University, Kingdom of Saudi Arabia. Journal of Family and Community Medicine | Published by Wolters Kluwe. 2016.*
4. *Pietinalho, A., Pelkonen, A., & Rytilä, P. (2009). Linkage between smoking and asthma: Linkage between smoking and asthma. Allergy, 64(12), 1722–1727. https://doi.org/10.1111/j.1398-9995.2009.02208.x*
5. *Lee, V. W. Y., Li, A., & Li, J. T. S. (2021). Burden of smoking in Asia-Pacific countries. Tobacco Induced Diseases, 19 (April), 28. https://doi.org/10.18332/tid/133633*
6. *Reitsma, M. B., Flor, L. S., Mullany, E. C., Gupta, V., Hay, S. I., & Gakidou, E. (2021). Spatial, temporal, and demographic patterns in prevalence of smoking tobacco use and initiation among young people in 204 countries and territories, 1990-2019. The Lancet. Public Health, 6(7), e472–e481. https://doi.org/10.1016/S2468-2667(21)00102-X*
7. *American College Health Association - National College Health Assessment II: reference group undergraduates executive summary. (2016).*
8. *Rayens, M. K., Ickes, M. J., Butler, K. M., Wiggins, A. T., Anderson, D. G., & Hahn, E. J. (2017). University students' perceived risk of and intention to use waterpipe tobacco. Health Education Research, 32(4), 306–317. https://doi.org/10.1093/her/cyx049*
9. *Shariful Islam, M., Rashid, M., Sizear, M. I., Hassan, R., Rahman, M., Parvez, S. M., Hore, S. C., Haque, R., Jahan, F., Chowdhury, S., Huda, T. M. N., Saif-Ur-Rahman, K. M., & Khan, A. (2022). Cigarette smoking and associated factors among men in five South Asian countries: A pooled analysis of nationally representative surveys. PloS One, 17(11), e0277758. https://doi.org/10.1371/journal.pone.0277758*
10. *Patil, S., Mahuli, A. V., & Warnakulasuriya, S. (2022). Effects of smoking shisha, cancer risk, and strategies for prevention of shisha habit. Journal of Oral Biology and Craniofacial Research, 12(4), 439–443. https://doi.org/10.1016/j.jobcr.2022.05.008*
11. *Musk, A. W., & de Klerk, N. H. (2003). History of tobacco and health. Respirology (Carlton, Vic.), 8(3), 286–290. https://doi.org/10.1046/j.1440-1843.2003.00483.x*
12. *Li, Y., & Hecht, S. S. (2022). Carcinogenic components of tobacco and tobacco smoke: A 2022 update. Food and Chemical Toxicology: An International Journal Published for the British Industrial Biological Research Association, 165, 113179.*

https://doi.org/10.1016/j.fct.2022.113179

13. *Prijić, Ž., & Igić, R. (2021). Cigarette smoking and medical students. Journal of B.U.ON.: Official Journal of the Balkan Union of Oncology, 26(5), 1709–1718.*
14. *Camenga, D. R., & Klein, J. D. (2016). Tobacco use disorders. Child and Adolescent Psychiatric Clinics of North America, 25(3), 445–460. https://doi.org/10.1016/j.chc.2016.02.003*
15. *Evans, L. M., Johnson, E. C., Melroy-Greif, W. E., Hewitt, J. K., Hoeffer, C. A., Keller, M. C., Saba, L. M., Stitzel, J. A., & Ehringer, M. A. (2020). The role of A Priori-identified addiction and smoking gene sets in smoking behaviors. Nicotine & Tobacco Research: Official Journal of the Society for Research on Nicotine and Tobacco, 22(8), 1310–1315. https://doi.org/10.1093/ntr/ntaa006*
16. *Grana, R., Benowitz, N., & Glantz, S. A. (2014). E-cigarettes: A scientific review. Circulation, 129(19), 1972–1986. https://doi.org/10.1161/circulationaha.114.007667*
17. *Erhabor, J., Boakye, E., Osuji, N., Obisesan, O., Osei, A. D., Mirbolouk, H., Stokes, A. C., Dzaye, O., El-Shahawy, O., Rodriguez, C. J., Hirsch, G. A., Benjamin, E. J., DeFilippis, A. P., Robertson, R. M., Bhatnagar, A., & Blaha, M. J. (2023). Psychosocial stressors and current e- cigarette use in the youth risk behavior survey. BMC Public Health, 23(1), 1080. https://doi.org/10.1186/s12889-023-16031-w*
18. *Office of the Surgeon General, & U S Department of Healt Human Services. (2017b). E- cigarette use among youth and young adults: A report of the surgeon general. Createspace Independent Publishing Platform.*
19. *Wężyk-Caba, I., Znyk, M., Zajdel, R., Balwicki, Ł., Tyrańska-Fobke, A., Juszczyk, G., Zajdel, K., Świątkowska, B., & Kaleta, D. (2022). Determinants of E-cigarette and cigarette use among youth and young adults in Poland-PolNicoYouth study. International Journal of Environmental Research and Public Health, 19(18), 11512. https://doi.org/10.3390/ijerph191811512*
20. *Wiener, R. C. (2013). Association of smokeless tobacco use and smoking in adolescents in the United States: an analysis of data from the Youth Risk Behavior Surveillance System survey, 2011. Journal of the American Dental Association (1939), 144(8), 930–938. https://doi.org/10.14219/jada.archive.2013.0212*
21. *Baniulyte, G., & Ali, K. (2023). E-cigarette side effects in otolaryngology: unveiling the vape mirage. Evidence-Based Dentistry, 24(4), 184–185. https://doi.org/10.1038/s41432-023-00941-0*
22. *Badran, M., & Laher, I. (2020). Waterpipe (shisha, hookah) smoking, oxidative stress and hidden disease potential. Redox Biology, 34(101455),101455. https://doi.org/10.1016/j.redox.2020.101455*
23. *Patil, S., Mahuli, A. V., & Warnakulasuriya, S. (2022). Effects of smoking shisha, cancer risk, and strategies for prevention of shisha habit. Journal of Oral Biology and Craniofacial Research, 12(4), 439–443. https://doi.org/10.1016/j.jobcr.2022.05.008*
24. *Tariq N, Gupta V., High Risk Behaviors. StatPearls, 2023*
25. *Agwu, A. (2020). Sexuality, sexual health, and sexually transmitted infections in adolescents and young adults. Topics in Antiviral Medicine, 28(2), 459–462.*
26. *Тэмүүлэн О. Тамхинаас гарах хүсэлтэй иргэдийн тамхи татаж буй шалтгаан, хэрэглээг судлах. Улаанбаатар: 2022. х. 11.*
27. *Сарангэрэл С. Мансууруулах бодисын талаарх өсвөр үе, залуучуудын мэдлэг, хандлага, хэрэглээ. Улаанбаатар: Эрхэс; 2019. х. 11.*
28. *Должин Н. Өсвөр насны хүүхдийн эрсдэлт зан үйлийг судалсан нь. Улаанбаатар: 2012. х. 9.*
29. *Хонгорзул Э. Халдварт бус өвчний талаарх оюутнуудын мэдлэг, зарим эрсдэлт хүчин зүйлсийг судлах нь. Улаанбаатар: 2022. х. 13.*
30. *Банзрагч Үүрцайх. 18-30 настай хүмүүсийн дундах электрон тамхины ойлголтын талаарх нөхцөл байдлыг үнэлэх нь. Улаанбаатар: АШУҮИС СС; 2022. х. 51.*
31. *Creamer, M. R., Everett Jones, S., Gentzke, A. S., Jamal, A., & King, B. A. (2020). Tobacco product use among high school students - Youth Risk Behavior Survey, United States, 2019. MMWR Supplements, 69(1), 56–63. https://doi.org/10.15585/mmwr.su6901a7*
32. *Bian, J., Du, M., Liu, Z., Fan, Y., Eshita, Y., & Sun, J. (2012). Prevalence of and factors associated with daily smoking among Inner Mongolia medical students in China: a cross- sectional questionnaire survey. Substance Abuse Treatment, Prevention, and Policy, 7(1), 20. https://doi.org/10.1186/1747-597X-7-20*
33. *Provenzano, S., Santangelo, O. E., Grigis, D., Giordano, D., & Firenze, A. (2019). Smoking behaviour among nursing students: attitudes toward smoking cessation. Journal of Preventive Medicine and Hygiene, 60(3), E203–E210. https://doi.org/10.15167/2421-4248/jpmh2019.60.3.1049*
34. *Ansari, T., Alghamdi, T., Alzahrani, M., Alfhaid, F., Sami, W., Aldahash, B., Aldukhayel, D., Alshanbah, F., & Almutairi, N. (2016). Risky health behaviors among students in Majmaah University, Kingdom of Saudi Arabia. Journal of Family & Community Medicine, 23(3), 133. https://doi.org/10.4103/2230-8229.189105*
35. *Hawash, M., Mosleh, R., Jarrar, Y., Hanani, A., & Hajyousef, Y. (2022). The prevalence of Water Pipe smoking and perceptions on its addiction among university students in Palestine, Jordan, and Turkey. Asian Pacific Journal of Cancer Prevention: APJCP, 23(4), 1247–1256. https://doi.org/10.31557/APJCP.2022.23.4.1247*
36. *Han, J.-O., Im, J.-S., Yim, J., Choi, Y.-H., Ko, K.-P., Kim, J., Kim, H. G., Noh, Y., Lim, Y.-K., & P r e v e n t i o n : APJCP, 16(13), 5531–5536. https://doi.org/10.7314/apjcp.2015.16.13.5531*
37. *Н.Должин. Өсвөр насны хүүхдийн эрсдэлт зан үйлийг судалсан нь. Улаанбаатар.2012он*
38. *Singh B, Chand SS, Chen H. Tobacco smoking initiation among students in Samoa and health concerns. PLoS One. 2021;16(10):e0258669. doi:10.1371/journal.pone.0258669*
39. *Romm KF, Metzger A, Gentzler AL, Turiano NA, eds. Transitions in Risk-Behavior Profiles among First Year College Students.*

Study on the Level of Smoking and Health Risk Behaviors among University Students

Namuuntsetseg B[1], Bayartsetseg A[1], Davaasuren Ts[1], Azjargal B[1]

[1]School of Nursing, IV grade student (401), MNUMS
[1]MNUMS, School of Nursing, DMMCHN
E-mail: Azjargal.b@mnums.edu.mn, Tel:+976-99102855

Background: In a study conducted in the United States, there is a possibility of negative health effects due to risky behavior. Most smokers (88%) started using tobacco before the age of 18years. In recent years, the use of e-cigarettes has increased in Mongolia, which can be seen by the fact that someone around us is using them. All tobacco products are addictive and involve risky behaviors. Risky behaviors are behaviors that pose a risk of harming one's own or others' health, causing morbidity or mortality. Therefore, there is no study on the level of smoking dependence and risky behavior among students, which is the basis of our study.

Aim: The study is aimed to evaluate the risky behavior and cigarette smoking among students who are studying the school of university.

Material and Methods: The study was conducted by using a cross sectional design and a quantitative research method. All students of the School of Nursing, MNUMS were included. First to fourth course students of nursing school were included on a voluntary basis.

Results: In the study, 87.8% of participants were female and 12.2% were male student. Furthermore, 50.2% of respondents are smokers. When the physical nicotine dependence test was taken from smoking students, moderate to high levels of dependence were identified, indicating there is behavioral risk. Risk behaviors are associated with factors such as safety, violence, bullying, feelings of sadness, use of tobacco and drugs, consumption of alcoholic beverages, changes in sexual orientation, and body weight.

Conclusions:

1. The students have limited scientific understanding and explanation regarding tobacco use.
2. Among the study participants, 5.4% had a very low level of dependence, 34% had a low level, 24.3% had a moderate level, 35.6% had a high level, and 0.54% had a very high level of dependence.
3. Risk behaviors related to health include tobacco use, alcohol consumption, marijuana use, bullying and violence, sexual activity, feelings of sadness or suicidal thoughts, screen dependence, and consumption of cola beverages.

Keywords: Understanding about cigarette smoke, Cigarette dependence, Health-related risky behavior